



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөхморьт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 24 № 124

танай _____ -ны № _____ -т

Г ХӨХМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
Г.ДАРЖАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөхморьт сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 1, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 87,794.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн,

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд зохион байгуулсан сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардалд 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар олгосон байна. Үүнээс 85,329.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, данс бүртгэлд авсан.

Засгийн газрын 2024 оны 231 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмсэн, мөн оны 83 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан хаагчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгожээ.

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор нийт 4 орон тоо нэмэгдсэн байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 475,318.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 612,823.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 137,455.3 мянган төгрөгөөр буюу 129.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,217,539.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 168,947.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Сумын орон нутгийн төсвөөс Ерөнхий боловсролын сургуульд 69,632.6 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан, сумын ойн хандив болон бусад эх үүсвэрээс 387,372.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөсөн нь 87.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П. ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	808,899.7	876,695.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	314,729.6	310,241.9
33	АВЛАГА	364,151.2	321,904.7
35	БАРАА МАТЕРИАЛ	123,571.4	124,188.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,447.5	120,360.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	933,360.0	1,610,604.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	933,360.0	1,610,604.4
39200	Биет хөрөнгө	932,288.0	1,610,604.4
39300	Биет бус хөрөнгө	1,072.0	1,072.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,742,259.7	2,487,299.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	103,946.2	68,977.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	103,946.2	68,977.7
41300	Өглөг	103,946.2	68,977.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,638,313.4	2,418,322.0
51	Засгийн газрын хувь оролцоо	1,638,313.4	2,418,322.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	527,021.1	527,021.1
51200	Хуримтлагдсан үр дүн	553,336.5	1,333,345.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	557,955.9	557,955.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,742,259.7	2,487,299.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,432,942.4	2,841,841.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	320,419.0	607,926.0
110	Орлогын албан татвар	245,887.9	489,902.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	266,843.4	536,422.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,955.5)	(46,519.7)
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,341.6	747,189.8
120	Нийтлэг татварын бус орлого	193,341.6	747,189.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,104,995.1	1,875,996.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,104,995.1	1,875,996.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,527.7	1,875,996.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,281.7	742,029.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,403.3	101,102.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,128.3	606,301.4
2104	Хангамж, бараа материалын зардал	63,318.9	41,901.6
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,973.8	40,104.1
2107	Томилолт, зочны зардал	21,751.0	15,655.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,885.2	25,546.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,290.5	260,665.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(52,513.6)	691,206.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,021.1	1,684,549.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,021.1	1,684,549.4
9	Тайлант үеийн үр дүн		(52,513.6)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,021.1	1,632,035.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	527,021.1	1,632,035.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,021.1	1,727,115.7
19	Тайлант үеийн үр дүн		691,206.4
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	527,021.1	2,418,322.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		1,337,501.9	2,143,710.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		320,419.0	607,926.0
110	Орлогын албан татвар		245,887.9	489,902.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		266,843.4	536,422.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(20,955.5)	(46,519.7)
113	Хөрөнгийн албан татвар		62,405.1	103,337.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		12,126.1	14,686.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		2,694.4	4,408.9
1181	Газрын төлбөр		9,431.7	2,662.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		50,135.6	49,059.6
120	Нийтлэг татварын бус орлого		50,135.6	49,059.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,022,947.3	1,486,725.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		951,310.4	1,650,329.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		951,310.4	1,650,329.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		870,955.4	1,663,639.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		467,281.7	742,029.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,403.3	101,102.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		27,931.9	552,967.7
2104	Хангамж, бараа материалын зардал		47,197.6	41,529.0
2105	Нормативт зардал		2,495.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		19,973.8	40,104.1
2107	Томилолт, зочны зардал		21,751.0	15,655.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		130,207.8	25,546.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		95,713.4	32,885.7

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		24,355.0	42,690.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		442,191.5	493,381.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		343,820.0	497,868.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		343,820.0	497,868.9
2200	Дотоод эх үүсвэрээр		343,820.0	497,868.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(343,820.0)	(497,868.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		98,411.5	(4,487.7)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		216,358.1	314,729.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		314,729.6	310,241.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,240,577.60	1,971,110.85	269,466.75	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,669,858.10	1,583,564.13	86,293.97	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,627,066.10	1,540,874.12	86,191.98	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	742,873.70	742,028.98	844.72	99.9
210101	Үндсэн цалин	245,873.70	343,138.53	-97,264.83	139.6
210102	Нэмэгдэл	497,000.00	348,595.03	148,404.97	70.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,275.00	101,102.30	172.70	99.8
210201	Тэтгэврийн даатгал	74,755.00	74,636.90	118.10	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,630.00	6,608.80	21.20	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,315.00	3,311.20	3.80	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,315.00	3,311.70	3.30	99.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,260.00	13,233.70	26.30	99.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	633,146.90	552,967.74	80,179.16	87.3
210301	Гэрэл, цахилгаан	18,100.00	17,594.61	505.39	97.2
210302	Түлш, халаалт	614,046.90	534,752.12	79,294.78	87.1
210303	Цэвэр, бохир ус	1,000.00	621.00	379.00	62.1
2104	Хангамж, бараа материалын зардал	40,706.50	39,367.44	1,339.07	96.7
210401	Бичиг хэрэг	6,662.50	6,285.60	376.90	94.3
210402	Тээвэр, шатахуун	27,150.00	26,277.79	872.22	96.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400.00	2,359.00	41.00	98.3

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100.00	60.00	40.00	60.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,394.00	4,385.05	8.95	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,000.00	64,097.32	902.68	98.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,000.00	23,993.20	6.80	100.0
210604	Урсгал засвар	41,000.00	40,104.12	895.88	97.8
2107	Томилолт, зочны зардал	15,702.00	15,655.50	46.50	99.7
210702	Дотоод албан томилолт	15,702.00	15,655.50	46.50	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,992.00	2,308.44	683.56	77.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500.00	1,165.00	335.00	77.7
210803	Даатгалын үйлчилгээ	60.00	50.00	10.00	83.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150.00	130.18	19.82	86.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90.00	54.00	36.00	60.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,162.00	880.00	282.00	75.7
210807	Газрын төлбөр	30.00	29.26	0.74	97.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,370.00	23,346.42	2,023.58	92.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,500.00	20,067.42	1,432.58	93.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,870.00	3,279.00	591.00	84.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,792.00	42,690.01	101.99	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,792.00	42,690.01	101.99	99.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,812.00	39,748.66	63.34	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,980.00	2,941.35	38.65	98.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,719.50	387,546.72	113,172.78	77.4
223001	Бусад хөрөнгө	500,719.50	387,546.72	113,172.78	77.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.00	0.00	70,000.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	70,000.00	0.00	70,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,240,577.60	2,001,490.91	239,086.69	89.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,007,577.60	1,957,829.22	49,748.38	97.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,717,858.10	1,680,857.38	37,000.72	97.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	289,719.50	276,971.84	12,747.66	95.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	233,000.00	43,661.69	189,338.31	18.7

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000.00	43,520.11	-13,520.11	145.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000.00	141.58	1,858.42	7.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	201,000.00	0.00	201,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	230,665.65	230,665.65	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	261,045.71	261,045.71	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан / мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,161.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,832.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,758.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,161.6
210402	Тээвэр, шатахуун	2,161.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,237.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,237.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,359.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,359.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,073.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,073.9
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	40,073.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,329.0
2200	Дотоод эх үүсвэрээр	85,329.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,329.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,161.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,161.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,500.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,179.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	482.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 2.0 сая төгрөгийн 2 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна. Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Авлагыг 1.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Бараа материалыг 0.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 70.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 70.2 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1.1 Харьяа байгууллагууд

Хөхморьт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил


Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 18.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 33.6 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна. Хөхморьт ОНХС-ийн аудит түүвэрт хамрагдаагүй.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 118.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 35.2 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 35.2 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар авлага, бараа материалтай холбоотой 2.0 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Аудитаар нийт 70.2 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 556.5 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 69.6 сая төгрөгийн 1 заалт зөвлөмжийг хүргүүлж байна.



3.3 Албан шаардлага

1. Бууны албан татвар 0.03 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.2 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 0.2 сая төгрөгөөр, нийт 0.5 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" Хөхморьт Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Хөхморьт сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллагуудад залруулагдаагүй 87.8 сая төгрөгийн 7 зөрчил илэрч 18.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 68.8 сая төгрөгийн 6 зөрчил нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Орон нутгийн төсвөөс 168.9 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсвөөс Ерөнхий боловсролын сургуульд тогтмол зардлын санхүүжилтийг олгохдоо нийт 69.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Хөхморьт Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолтой нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагуудад санхүүжилтийг бүрэн олгон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөхморьт сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	2,037.1			1	2,037.1	1	2,037.1		
Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар	4	118,464.00			4	118,464.00	4	118,464.00		
Хөхморьт сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	2,965.9			3	2,965.9	3	2,965.9		
Дүн	8	123,467.0	0	0	8	123,467.0	8	123,467.0	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүтд	Өөрчлөлтгүй	Хязгарлагтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт татгалзах	Нийт зөрчил		Үүнээс									
							Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөхморьт сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	-	3	70,189.1	3	70,189.1	-	-	-	-	-	-	-	-
Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	2	35,162.8	2	35,162.8	-	-	-	-	-	-	-	-
Хөхморьт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	1	-	3	5,587.0	3	5,587.0	-	-	-	-	-	-	-	-
Хөхморьт сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөхморьт сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хөхморьт сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	1	-	1	18,956.2	1	18,956.2	1	28,088.9	-	-	-	-	-	-
Дүн	6	1	1	-	-	4	10	157,984.0	1	18,956.2	9	139,027.8	-	-	-	-	-	-

(мянган төгрөг)

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

	Байгууллагын нэр		Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр						
		Аудитад хамрагдах				Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийсэгүй	Өөрчлөлтий	Хязгарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	-	-	3	-	4	-	5	-	-	-	10
1	ТШЗ	1	-	1	-	-	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	-	1	-	4	-	5	-	-	-	10

